



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар ХЭГ/1975

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын өр, түүний эргэн төлөлтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0007390

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭЭС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Эдийн засгийн өсөлт 2018 оны байдлаар 6.9 хувьд хүрсэн талаар Засгийн газраас байнга онцолж ярих боллоо. Өнөөдөр дэлхийн эдийн засаг сэргэж, гадаад зах зээлийн эрэлт нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа нь Монгол улсын эдийн засагт сэргэлт авчраад байгаа. Зэсийн баяжмал, төмрийн хүдэр, газрын тос, цайрын баяжмал, алт зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүнүүд 2018 онд өссөн үзүүлэлттэй, цаашид ч нэмэгдэх төлөвтэй байна. Нөгөө талаар олон улсын санхүүгийн байгууллага, донор орнуудаас их хэмжээний валют манай эдийн засагт орж ирж байгаа. Гэтэл Монгол Улсын гадаад өр ямар учраас өсөөд байна вэ?

Макро эдийн засгийн орчныг тогтворжуулах, өсөлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн төсөв, санхүүгийн тууштай бодлогын үр дүнд 2016 онд 1.2 хувь өсөөд байсан эдийн засгийн өсөлт 2019 оны 1 дүгээр улиралд 8.6 хувьд хүрч байна. Өмнөх онуудад гаргасан өндөр хүүтэй, арилжааны нөхцөлтэй зээллэгүүдийг хугацаанд нь төлж барагдуулан, шинээр арилжааны зээл авахгүй байх бодлогыг баримталсны үр дүнд Засгийн газрын өр буурсан. Эдийн засгийн өсөлт нэмэгдсэнээр аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд үйл ажиллагаагаа өргөтгөх, санхүү, эдийн засгийн эерэг хүлээлтийг үүсгэж гадаадын шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг болон хувийн хэвшлийн гадаад өр нэмэгдэж байна.

Монгол Улсын нийт гадаад өр 2018 оны байдлаар 28.7 тэрбум ам.доллартой тэнцэж байна. Үүнээс 7.2 тэрбум ам.доллар буюу нийт гадаад өрийн 25 хувьтай тэнцэх гадаад өрийг Засгийн газар, 2.0 тэрбум ам.доллар буюу нийт гадаад өрийн 7 хувьтай тэнцэх гадаад өрийг Төв банк, 2.2 тэрбум ам.доллар буюу нийт гадаад өрийн 8 хувьтай тэнцэх гадаад өрийг Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагууд, 8.0 тэрбум ам.доллар буюу нийт гадаад өрийн 28 хувьтай тэнцэх гадаад өрийг хувийн хэвшил, бусад төрлийн байгууллагууд, 9.2 тэрбум ам.доллар буюу нийт өрийн 32 хувьтай тэнцэх гадаад өрийг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар компани хоорондын зээллэгийн хүрээнд үүссэн өрүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын нийт гадаад өр /сая ам.доллар/

Үзүүлэлт	2017 он	2018 он	Өөрчлөлт (өмнөх өнөөс)
Засгийн газар	7,321.0	7,184.2	(136.8)
Төв банк	2,025.1	2,030.2	5.1
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,194.3	2,230.4	36.1
Бусад салбарууд (Монгол Улсын хөгжлийн банк болон бусад)	7,955.8	8,041.9	86.0
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	7,996.5	9,228.2	1,231.7
Нийт	27,492.7	28,714.9	1,222.2

Эх сурвалж Монгол банк

Монгол Улс 2016, 2017 онуудад алт, зэс, нүүрс зэрэг гол экспортын нэрийн бүтээгдэхүүний үнийн бууралт болон төсөв, мөнгөний алдаатай бодлогоос үүдэлтэй эдийн засгийн хямралыг давах зорилгоор Олон Улсын Валютын Сан/цаашид ОУВС

гэх/-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 2017 оны 05 дугаар сараас эхлэн хэрэгжүүлсэн.

Эдийн засгийн хямралыг давахад тэргүүн ээлжид 2009 оноос хойш хамгийн доод түвшиндээ хүрээнд байсан гадаад валютын албан нөөцийг бууруулахгүйгээр гадаад үнэт цааснуудын төлбөрийг гэрээний хугацаанд төлөх, гадаад валютын албан ханшийг тогтвортой барих хэмжээний гадаад валютын албан нөөцийг бүрдүүлэх шаардлагатай байсан.

Улсын нийт гадаад өрийн статистикийн бусад салбарууд хэсэгт бүртгэгддэг Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын гадаад үнэт цаасны төлбөрийг Засгийн газрын зүгээс шинээр үнэт цаас гарган төлж барагдуулсан, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлтэй валютын зээл авч гадаад валютын албан нөөц нэмэгдүүлсэн, Монгол Улсын Засгийн газраас 2012 онд олон улсын санхүүгийн зах зээл дээр арилжаалсан 500.0 сая ам.долларын “Чингис” үнэт цаас болон 2015 онд арилжаалсан 1.0 тэрбум юанийн “Димсам” үнэт цаас (161.2 сая ам.доллар)-ыг гадаад валютын албан нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр дахин санхүүжилт хийсэн зэргээс шалтгаалан Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 2017 онд нэмэгдсэн бол 2018 оны эцэст 7,184.2 сая ам.долларт хүрч өмнөх оноос 136.8 сая ам.доллаароор буурсан.

Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр 1.3 тэрбум ам.доллар хүртэл буураад байсан гадаад валютын албан нөөц 3.8 тэрбум ам.доллар хүртэл нэмэгдэж, эдийн засгийн өсөлт нэмэгдэх, төсвөөс эргэн төлөгдөх өрийн дарамтыг бууруулах, хүүгийн зардал буурах суурь нөхцөл болсон.

Асуулга 2. Монгол улсын Засгийн газрын өр 2016 оны 6 дугаар сараас хойш 5 их наяд 749 тэрбум төгрөг буюу ойролцоогоор хоёр “Чингис бонд”-ын хэмжээтэй өссөн байна. Энэ мөнгөөр хийсэн бүтээн байгуулалтын тайланг ирүүлнэ үү?

Засгийн газрын өр 2016 оны эцэст 22.3 их наяд төгрөгт хүрч 2016 оны 06 дугаар сарын 30-ны байдалтай харьцуулахад 5.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Засгийн газрын өр 2016 оны эцэст ийнхүү нэмэгдсэн нь Сайн хөтөлбөрүүд, вексель, “барих-шилжүүлэх” төрлийн концесс, Хөгжлийн банкны санхүүжилт зэрэг төсвөөс гадуур хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн байсан. Эдгээр төсвөөс гадуурх үйл ажиллагааг төсөвт нэгтгэснээр төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ны 18 хувьд хүрч, гадаад валютын албан нөөц эрс багасаж төгрөгийн ханш сулрах нөхцөл бүрдсэн байсан нь Засгийн газрын баримталж байгаа бодлогын нөлөөгөөр сайжирч байна.

Засгийн газрын өр 2016 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 16.6 их наяд төгрөг, 2016 оны эцэст 22.3 их наяд төгрөг, 2017 оны эцэст 22.8 их наяд төгрөг, 2018 оны эцэст 22.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Засгийн газрын өр 5.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь дараах шалтгаантай. Үүнд:

1.Сайн хувьцаа, Сайн оюутан, Сайн малчин хөтөлбөрүүдийн хүрээнд арилжаалсан 596.0 тэрбум төгрөгийн үнэт цаас;

2.2012-2016 онд хөрөнгө оруулалтын вексель, барих-шилжүүлэх төрлийн концесс, Хөгжлийн банкаар дамжуулан төсөл хөтөлбөр санхүүжүүлсэн зэрэг төсвийн бус шинжтэй үйл ажиллагааг ихээр хэрэгжүүлсний улмаас 2016 оны Төсвийн алдагдал ДНБ-ны 18.0 хувьд хүрч дотоод үнэт цаас их хэмжээгээр гаргасан;

3.Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 1962.5 төгрөг байсан бол жилийн эцэст 2,489.5 төгрөгт хүрч суларснаас голлон шалтгаалсан.

Хүснэгт 2: Засгийн газрын өр, /тэрбум төгрөг/

Засгийн газрын өр	2016 он	2017 он	2018 он
Засгийн газрын дотоод өр	5,796.0	3,461.9	1,564.7
Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8	18,865.6
Засгийн газрын баталгаа	3,451.5	1,663.7	1,130.7
Барих-шилжүүлэх төрлийн концесс	668.9	768.2	806.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР	22,280.1	22,751.6	22,367.0
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	88.0%*	85.0%	80.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	78.8%	72.5%	58.9%
Тайлант үеийн ам.долларын ханш	2,489.5	2,427.1	2,642.9

Засгийн газар 2016 оны 6 дугаар сараас 2019 оны 3 дугаар сарын 31-ний хооронд хөтөлбөрийн зээлийн хүрээнд 796.0 сая ам.доллар, төслийн зээлийн хүрээнд 999.8 сая ам.доллар нийт 1,795.8 сая ам.доллар авч ашигласан.

Гадаад төслийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төсөл арга, хэмжээ нь төсөвт тусгагдан, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад зарцуулагдаж байна. Томоохон ашиглалт гарсан төслүүдээс дурдвал Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн санхүүжилтэд 214.3 сая ам.доллар, Улаанбаатар-Хөшигтийн хөндийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төслийн санхүүжилтэд 131.8 сая ам.доллар, Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөлд 66.6 сая ам.доллар, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 61.7 сая ам.доллар, Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам барих төсөлд 49.2 сая ам.доллар, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих төсөлд 36.5 сая ам.долларыг тус тус зарцуулаад байна.

Асуулга 3. Монгол Улсын нэгдсэн төсөв зөвхөн сүүлийн гурван жилийн хугацаанд 7 орчим их наяд төгрөгийн алдагдалтай батлагдсан. Үүнийг өр тавьж шийдэж байна. Гэтэл Сангийн сайд Ч.Хүрэлбаатар “У.Хүрэлсүхийн Засгийн газар байгуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 6.6 их наяд төгрөгийн өр төлж барагдуулсан” гэж олон нийтэд мэдээлж байна. Энэ хаанаас ямар эх үүсвэрээр, хэн гэдэг Ерөнхий сайд, хэн гэдэг Сангийн сайдын үеийн өр төлсөн талаар тодорхой тайлбар өгч, жагсаалт гаргаж ирүүлнэ үү.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Засгийн газар байгуулагдаж төсөв, санхүү, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зарлагыг багасгах бодлогыг баримтлан төсвийн алдагдлыг

бууруулсны үр дүнд нийт 7.1 их наяд төгрөгийн өр төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулаад байна.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.8 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар батлагдсанаас гүйцэтгэлээр 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай, Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.7 их наяд төгрөгийн алдагдалтай батлагдсанаас гүйцэтгэлээр 11.9 тэрбум төгрөгийн ашигтай, Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.3 их наяд төгрөгийн алдагдалтай батлагдсанаас 2019 оны 05 сарын гүйцэтгэлээр 146.1 тэрбум төгрөгийн ашигтай гараад байна. Хэдийгээр 2017-2019 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт алдагдлын баталсан хэмжээ 7.7 их наяд төгрөг байсан хэдий ч төсөв, санхүү, мөнгөн хөрөнгийг оновчтой удирдаж, төсвийн орлогыг нэмэгдүүлж, төсвийн үр ашиггүй зардлыг хязгаарлан төсвийн сахилга батыг сайжруулснаар төлөвлөгөөт алдагдал 6.2 их наяд төгрөгөөр буурч, 2017-2019 оны 5 дугаар сар хүртэлх 3 жилийн төсвийн тэнцэл 1.6 их наяд төгрөг байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдал гүйцэтгэлээр төлөвлөгөөт хэмжээнээс буурснаар Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого, өмч хувьчлалын орлого зэрэг төсвийн алдагдал нөхөх эх үүсвэр болон мөнгөн хөрөнгийн хуримтлалыг Засгийн газрын өрийг төлөхөд зарцуулах боломж бүрдсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдаар Ухнаагийн Хүрэлсүх томилогдож, Засгийн газраа байгуулснаас хойш буюу 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 31-нийг дуустал 5.4 их наяд төгрөгийн үндсэн төлбөр, 1.7 их наяд төгрөгийн хүүгийн төлбөр, нийт 7.1 их наяд төгрөгийн өр, төлбөрийг төлж барагдуулснаас 2017 оны 04 дүгээр улиралд 2.8 их наяд төгрөг, 2018 онд 3.8 их наяд төгрөг, 2019 оны 05 сарын байдлаар 0.6 их наяд төгрөгийг тус тус төлөөд байна.

Засгийн газар 2011 оны жилийн эцсийн байдлаар олон улсын зах зээлд гадаад үнэт цаас арилжаалаагүй байсан бол 2012 онд 1.5 тэрбум ам.долларын "Чингис" үнэт цаас, 2015 оны 6 дугаар сард 1.0 тэрбум юанийн "ДимСам" үнэт цаас, 2016 оны 4 дүгээр сард 500.0 сая ам.долларын "Мазаалай" үнэт цаасыг тус тус гаргасан. Засгийн газрын зүгээс 2017 оны 10 дугаар сараас 2019 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд гадаад үнэт цаасны төлбөрт 2.4 их наяд төгрөгийн төлбөрийг төлснөөс 2012, 2015 онд арилжаалсан "Чингис", "ДимСам" үнэт цаасны үндсэн төлбөрт 1.6 их наяд төгрөг төлсөн бөгөөд гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 0.8 их наяд төгрөгийг төлөөд байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш буюу 1991 оноос хойш түншлэгч улс орон, олон улсын санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг авч ашигласаар ирсэн бөгөөд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 5.6 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг авч ашигласан. Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн түвшин 0.0%-3.0%, зээлийг 20-45 жилийн хугацаанд эргэн төлдөг.

Монгол Улсын Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас 2019 оны 05 дугаар сарын хооронд Кредит Свисс банкнаас 2016 оны 03 дугаар сард авсан 250.0 сая ам.долларын арилжааны нөхцөлтэй синдикат зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт 267.8 тэрбум төгрөг, бусад хөнгөлөлттэй гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт 867.3 тэрбум төгрөг нийт 1,135.1 тэрбум төгрөг төлсөн.

Хүснэгт 3. Гадаад зээлийн төлбөр, 2017.10-2019.05 сар, /тэрбум төгрөг/


Зээлдүүлэгч	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт
Абу-Даби сан	5.1	1.1	6.2
Австри	-	4.1	4.1
Азийн хөгжлийн банк	224.7	98.9	323.6
Герман	23.1	5.7	28.8
Дэлхийн банк	77.1	33.6	110.7
Европын хөрөнгө оруулалтын банк	-	0.4	0.4
Испани	8.0	0.6	8.5
Кредит Свисс банк	123.0	144.8	267.8
Кувейтын сан	30.5	7.7	38.2
Нордикийн хөгжлийн сан	6.4	1.4	7.8
Солонгос	18.5	3.5	21.9
Франц	3.0	0.8	3.8
ХААХОУХС	5.1	1.5	6.6
Хятад	-	71.8	71.8
Швед	2.6	0.1	2.6
Энэтхэг	-	0.1	0.1
Япон	169.0	36.3	205.3
Бусад	0.6	26.4	27.0
Нийт	696.4	438.7	1,135.1

Дотоод үнэт цаасны төлбөрт нийтдээ 3.9 их наяд төгрөг төлснөөс 3.3 их наяд төгрөгийн үндсэн төлбөр, 0.6 их наяд төгрөгийн хүүгийн төлбөрийг төлсөн.

Засгийн газар 2012 оноос Монголбанкаар, 2014 оноос Монголын хөрөнгийн биржээр дамжуулан төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор дотоод үнэт цаасыг тогтмол арилжаалж эхэлсэн нь үнэт цаасны үлдэгдлийг жил бүр нэмэгдэхэд нөлөөлсөн.

Дотоод үнэт цаасны дийлэнх хэсэг нь 1 жил буюу түүнээс богино хугацаатай арилжаалагддаг бөгөөд Засгийн газраас 2017 онд арилжаалсан үнэт цааснууд нь өмнөх онуудын үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цааснууд байсан. Дотоод үнэт цаасны үлдэгдэл 2011 оноос тогтмол нэмэгдэж ирсэн нь 2017, 2018 онд төлөгдөх дотоод үнэт цаасны төлбөрийг нэмэгдүүлж, төсөвт учруулах дарамтыг ихэсгэсэн.

График 1: Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/



Засгийн газар 2017 оны 10 дугаар сарын 24-өөс дотоод үнэт цаас арилжаалахыг зогсоож, 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авах

үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд 2017 оны 10 дугаар сараас дотоод үнэт цаасны үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөгөөр, 2019 оны 5 дугаар сарын байдлаар 3.1 их наяд төгрөгөөр буураад байна.

Асуулга 4. ОУВС-ын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд орж ирсэн зээл, тусламж болон 2016 оны 6 дугаар сараас хойш Монгол улсын Засгийн газрын бусад улс, санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн хэмжээ, хүү, авсан огноогоор нь жагсаалтаар ирүүлнэ үү?

ОУВС-ын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Олон улсын валютын сангаас төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор 157.2 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх зээлийг Монголбанкинд олгоод байгаа бөгөөд төсвийн дэмжлэгийн хэлбэрээр Засгийн газар нийт 796.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглаад байна.

Засгийн газар шинэчлэн байгуулагдсанаас хойш арилжааны нөхцөлтэй гадаад зээл шинээр аваагүй бөгөөд зөвхөн хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээг олон улсын банк санхүүгийн байгууллага, хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр төсөл арга хэмжээний хүрээнд 2016 оны 06 дугаар сараас 2019 оны 03 дугаар сарын 31-ний хооронд 999.8 сая ам.долларын зээлийг ашигласан. Мөн ОУВС-ын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Засгийн газар нийт 796.0 сая ам.долларын төсвийн дэмжлэгийн зээлийн эх үүсвэрийг 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар авч ашиглаад байна.

Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Гадаад зээлийн ашиглалт, /сая ам.доллар/

Санхүүжүүлэгч байгууллага	Хүү	2017 он	2018 он	2019.03.31
I. Төслийн зээл		313.1	400.8	96.8
Австри	0.0%	6.8	8.9	1.6
Азийн хөгжлийн банк	1.5%-2.0%	71.5	123.8	5.0
Герман	0.75%	0.6	7.0	-
Дэлхийн банк	1.5%-2.0%	17.1	15.7	1.3
ЕХОБанк	0.81%	-	5.9	10.4
Кувейтын сан	3.0%	0.4	0.0	-
Солонгос	0.25%	4.9	15.5	-
Франц	0.73%-0.9%	0.5	0.1	-
ХААХОУС	0.75%-2.0%	1.6	1.8	-
Хятад	2.0%	69.5	182.1	56.0
Энэтхэг	0.75%-1.75%	0.2	0.7	-
Япон	0.1%-0.3%	140.0	39.1	22.5
II. Хөтөлбөрийн зээл		606.0	190.0	-
Азийн хөгжлийн банк	Libor+0.5%	200.0	150.0	-
Дэлхийн банк	2.0%	122.7	-	-
Солонгос	1.5%	-	40.0	-
Япон	0.8%	283.2	-	-
Нийт		919.0	590.8	96.8

Асуулга 5. “Өрийг өрөөр дарах нь архиар шараа тайлахтай адил” гэсэн дүгнэлтийг өнгөрсөн парламентын үед УИХ дахь МАН-ын бүлгээс томилогдож ажилласан ажлын хэсгээс гаргаж байв. Үндсэндээ манай улсын өрийн тааз хэтэрч, Дорж Дулмаад өрөө дарахын тулд Бурмаагаас зээлж төлөхийг шүүмжилсэн дүгнэлтийг МАН сөрөг хүчин байхдаа хийж байсан. Тэгвэл Сү.Батболдын Засгийн газрын үед авсан 580 сая ам.долларын “Евро” бондыг “Хуралдай” бондоор, “Чингис бонд”-ын эхний 500 сая ам.доллар болон УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын Сангийн сайд байхдаа авсан “ДимСам” бондуудыг 2018 оны нэгдүгээр сард “Гэрэгэ” бонд гаргаж 800 сая ам.долларын өр зээл шинээр тавьсан нь “өрийг өрөөр сольж хугацаа сунгасан” уу эсвэл Сангийн сайдын хэлснээр өр төлөгдсөн үү.

Засгийн газар 2012 онд гаргасан “Чингис” үнэт цаасны 500.0 сая ам.доллар, 2015 онд гаргасан Дим сам үнэт цаасны 161.2 сая ам.долларын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулсан.

Засгийн газрын өрийн 2016, 2017 оны нөхцөл байдлыг тодорхойлбол ирэх онуудын өр төлбөрийг төлөх бэлтгэл ажлыг бүрэн хангаагүйн зэрэгцээ гадаад валютын нөөц 1.3 тэрбум ам.доллар хүртэл буурсан, нэгдсэн төсвөөс гадуур их хэмжээний зарцуулалт хийж төсвийн алдагдал нэмэгдэн эдийн засгийн хямралд ороод байсан зэрэг нь 2017, 2018 онд төлөгдөх хуваарьтай байсан олон улсын зах зээлд гаргасан гадаад үнэт цааснуудын төлбөрийг төлөх санхүүгийн чадавхгүй болгож, гадаад төлбөрийн дарамтад оруулсан.

Тухайн үед Засгийн газрын зүгээс бодит нөхцөл байдлыг шуурхай тодорхойлон ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлүүлснээр гадаад валютын албан нөөцийг үе шаттай нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээн, харьцангуй бага өртөгтэй урт хугацаатай үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах боломжийг бүрдүүлсэн.

ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх үед Засгийн газар 600.0 сая ам.долларын “Хуралдай” үнэт цаасыг 8.75 хувийн хүүтэй, 7 жилийн хугацаатай гаргаж байсан бол 2017 оны 11 дүгээр сард олон улсын зах зээлд арилжаалсан 800.0 сая ам.долларын “Гэрэгэ” үнэт цаас нь 5.625 хувийн хүүтэй 5.5 жилийн хугацаатай байсан.

Ингэснээр гадаад валютын албан нөөц болон төсөвт ачаалал үзүүлэлгүйгээр 500.0 сая ам.долларын “Чингис” үнэт цаас, 161.2 сая ам.долларын “ДимСам” үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж барагдуулсан бөгөөд шинээр гаргасан “Хуралдай” болон “Гэрэгэ” үнэт цаас нь 2023-2024 онд төлөгдөх нөхцөлтэй бөгөөд 2016 оны 4 дүгээр сард арилжаалсан “Мазаалай” үнэт цааснаас хугацаа урт, хүүгийн түвшин 2.1-5.3 хувиар бага, өрийн дарамтад бага нөлөөлөх нөхцөлтэй үнэт цааснууд болно.

-----oOo-----